

Увс аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд бие даан нэр дэвшигч

Гэрэлцогт овогтой Батбаярын сонгуулийн мөрийн хөтөлбөр

1. Биеийн тамир, спортыг хөгжүүлэх бодлогыг дэмжин, багийн спортыг хөгжүүлэх орчин, нөхцлийг бүрдүүлнэ
2. Улаангомын хотын гудамж, талбайн тохижилтыг сайжруулж, иргэдийн аюулгүй, ая тухтай амьдрах орчин нөхцлийг бүрдүүлэхэд анхаарч ажиллана
3. Төр-хувийн хэвшил-иргэний нийгмийн байгууллагын түншлэл, хамтын ажиллагааг дэмжин хөгжүүлнэ
4. Төсөв, санхүүгийн зарцуулалт, төрийн худалдан авалт, тендер сонгон шалгаруулалтанд иргэд, иргэний нийгмийн байгууллагын хяналт тавих боломжийг бүрдүүлж, авлига ашиг сонирхлоос ангид төрийн үйлчилгээг хөгжүүлэхэд санал, санаачлага гарган ажиллана
5. Төрийн албаны сул орон тоонд шударга сонгон шалгаруулалт хийхэд иргэд, иргэний нийгмийн байгууллагын хяналт, оролцоог хангах боломж нөхцлийг бүрдүүлэхэд анхаарч ажиллана
6. Байгаль орчныг хамгаалах иргэдийн нөхөрлөлийн үйл ажиллагааг дэмжин хөгжүүлж, байгаль орчинд сөргөөр нөлөөлөх үйл ажиллагаа явуулж буй иргэд, байгууллагуудын хууль бус үйл ажиллагаа, үйлчилгээд хянант тавьж, иргэдийн эрх ашгийг хамгаалан ажиллана

2020 оны 07 сарын 24-ний өдөр

Улаангом сум